

“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 он 3 сар 14 өдөр

Дугаар: 19/03/02

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 64.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 2.1, 2.3 дахь заалтууд, компанийн дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Евразия капитал холдинг ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 4-р сарын 30-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Олимпийн гудамж, Реженси Резиденс байр 3-р давхарт 314 тоот өрөөнд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 4-р сарын 05-ны өдрөөр тогтоосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
 2. Компанийн 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 3. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
 4. Бусад.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2019 оны 3 дугаар сарын 18-нд өдөр тутмын сонин, радио телевизийн аль нэгээр болон МХБ-ийн сайтаар; 2019 оны 4-р сарын 04-нд уг зарыг давтан, 2019 оны 3-р сарын 21-ний дотор брокерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2019 оны 4-р сарын 30-ны өдрийн 10 цагаар тасалбар болгосугай.
6. Ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 1-р, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р, хурлын дэгийг Хавсралт 3-р тус тус баталсугай.
7. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг 2019 оны 3-р сарын 21 өдөр гэхэд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /Г.Оюунболд/-т даалгасугай.
8. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг компаниас гаргуулсугай.

9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх Захирал Г.Оюунболдыг, гишүүнээр шинжээч У.Анарыг, Тооллогын комиссийн даргаар Ж.Ганзориг, гишүүнээр О.Мэндбаяр нарыг тус тус томилсугай.
10. “Евразиа капитал холдинг ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ХАЛИУНАА